



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 185

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авч бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалт, Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн өмчөөс шилжүүлсэн тус аймаг дахь Нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 195,000,000.00 (нэг зуун ерэн таван сая) төгрөгийн балансын үнэ, 65,000,000.04 (жаран таван сая төгрөг дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг төрийн өмчид хүлээн авч Халдварт өвчин судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Анхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Ажлын хэсэг байгуулан хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Тээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000447
7-r huraldaan.docx

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧӨӨС ШИЛЖУУЛСЭН
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ
ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

д/д	Автомашин шилжүүлэгч байгууллагын нэр	Тусгай зориулалтын автомашины, арал, улсын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг	Volkswagen LT46TDIMWB маркийн WV1ZZZ2FZC7002579 арлын, 6946ДАР улсын дугаартай	2012/2014	195,000,000.00	65,000,000.04	129,999,999.96
				195,000,000.00	65,000,000.04	129,999,999.96
				(нэг зуун ерэн таван сая)	(жаран таван сая дөрвөн мөнгө)	(нэг зуун хорин есөн сая есөн зуун ерэн есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн зургаан мөнгө)